

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. “КОВИД-19” БОЛОН БУСАД ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО:

1.1. “Ковид-19” болон бусад халдварт цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.

1.2. Коронавируст халдвар /Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг сумын төсвийн боломжид үндэслэн төлөвлөн батлуулж, цар тахлын үед эрүүл мэндийн байгууллагын оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисыг урьдчилан нөөцлөх, түргэвчилсэн оношлуураар хангана.

1.3. Иргэд, олон нийтэд “Ковид-19” халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

1.4. “Ковид-19” цар тахлын дэгдэлтийн үед эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт, үйл ажиллагааг тасалдуулахгүй явах нөхцөл боломжоор хангаж ажиллана.

1.5. Томуу, томуу төст өвчин, улаанбурхан, улаанууд зэрэг амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх, сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг дархлаажуулалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.

1.6. “Ухаалаг цахим сургалт”-ын орчинг нэмэгдүүлэн, хичээл, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, багш нарын мэдлэг ур чадвар, эцэг эхчүүдийн оролцоог дээшлүүлнэ.

1.7. Онцгой нөхцөл байдлын үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг, хариу арга хэмжээг шуурхай авч, тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн өрх, иргэдэд үзүүлэх халамж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.8. Коронавируст халдвар /Ковид-19/-ын эдийн засагт үзүүлэх нөлөөг багасгах зорилгоор Засгийн газар болон аймгаас хэрэгжүүлж буй бодлогыг суманд зохион байгуулж, жижиг дунд үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

2.1. Эрүүл мэнд:

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

2.1.1. Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг жил бүр зохион байгуулна.

2.1.2. Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх “Эрүүл, идэвхтэй амьдрал”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл гэр бүл-Эрхэм баян” арга хэмжээнүүдийг зохион байгуулна.

2.1.3. Эрүүл мэндийн үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

2.1.4. Сумын хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл эндэгдэл, осол гэмтэлийн шалтгааныг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чиглүүлнэ.

2.1.5. Иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд цахим технологийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

2.1.6. Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмад настан, зорилтот бүлгийн иргэдийн дунд идэвхтэй эрүүл амьдралын хэвшлийг бий болгох арга хэмжээ авч ажиллана.

2.1.7.Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгож, **“Эрүүл хүүхэд-Эрүүл Ирээдүй”** эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж, эрүүлжүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна.

2.1.9.Сумын Эрүүл мэндийн төвийг стандартад нийцсэн эмийн сан, шүдний эмчтэй болгож, шүдний кабинетийг тохижуулж, урсгал засварыг хийнэ.

2.1.10.Эмч, эмнэлгийн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангаж, мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ.

2.2. Боловсрол:

Хөгжлийг түүчээлэх чадвартай Монгол хүнийг хөгжүүлнэ.

2.2.1.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Мэргэжил сонголт” арга хэмжээг үе шаттай зохион байгуулж, гадаад, дотоодын их, дээд, ерөнхий боловсролын сургууль болон бусад боловсролын байгууллагуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллана.

2.2.2.“Сургалтын байгууллага-тоног төхөөрөмж” арга хэмжээг суманд зохион байгуулна.

2.2.3. “Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж багш нарын ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулна. Багш нарын ур чадварыг дээшлүүлж **“Чадварлаг багш”** арга хэмжээг зохион байгуулна.

2.2.4.Судалгаа, арга зүйн байгууллагуудтай хамтран сургууль, цэцэрлэгийн сургалтын чанарыг сайжруулна.

2.2.5.Хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн илрүүлж, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх **зорилгоор спорт болон урлаг заалыг тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.**

2.2.6.Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.7.Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, засвар хийх ажлыг улс, аймгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэнэ.

2.2.8.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна орчинг Эко тоглоомтой болгож, анги бүлгүүдийг сургалтын хэрэглэгдэхүүн болон биеийн тамирын хэрэглэгдэхүүнээр хангаж, зөөлөн хатуу эдлэлийн шинэчлэл хийнэ.

2.2.9.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЕБС-ийн 100 хүүхдийн ортой дотуур байрыг ашиглалтанд оруулна.

2.2.10. ЕБС-д сэтгэл зүйн үйлчилгээ болон эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

2.2.11. Сургууль цэцэрлэгийг монгол үндэсний өв соёлын наадгайгаар хангана.

2.1.12.Иргэдийн оролцоо ба сайн дурын ажилтанг хөхүүлэн дэмжинэ.

2.2.13. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажиллах нөхцөл бололцоог хангана.

2.2.14. Сургуулийн орчинд туршилтын эко талбайтай болгоно.

2.3.Биеийн тамир, спорт:

Биеийн тамир, спортыг дэмжих замаар хүний дундаж наслалтыг үртасгана.

2.3.1.“Спортлог Сантчууд” арга хэмжээг хэрэгжүүлж, иргэдийн дунд Сумын Засаг даргын нэрэмжит спортын уралдаан тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна.

2.3.2.**Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, “Эрүүл иргэний төлөө хамтдаа”** хөдөлгөөнийг сумын хэмжээнд өрнүүлж, үр дүнг тооцно.

2.3.3.Үндэсний спортын төрлөөр хичээллэгсэд болон сонирхогчдын тоог нэмэгдүүлж, хүүхэд залуучуудад үндэсний сур харвааг өвлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

2.3.4.Спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж,өвлийн спортыг дэмжиж ажиллана.

2.3.5.Хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжлийг дэмжих зорилгоор заавал биелүүлэх спортын норм, нормативыг насны ангиллаар тогтоон нэмэгдүүлж .

2.3.6. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

2.4. Соёл, урлаг:

Хүний хөгжилд соёл урлагийн үр нөлөөг нэмэгдүүлж, соёл уламжлалаа дээдэлдэг иргэн төлөвшүүлнэ.

2.4.1. Ардын авьяастан, хүүхэд, залуучууд уран бүтээлчдийг улс, аймгийн чанартай уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлнэ.

2.4.2. Монгол ахуй, өв соёл зан заншлыг илтгэсэн соёлын биет өвийг сэргээн засварлах, биет бус өвийг өвлөн үлдээх, олон нийтэд таниулж түгээнэ.

2.4.3. Монгол өв соёлоо ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авьяастнуудыг алдаршуулж, монгол тоглоом наадгайг сурталчилж, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлсэн арга хэмжээг зохион байгуулна.

2.4.4. Сумын номын сангийн баяжилтыг жил бүр нэмэгдүүлж, цахим номын сангийн хэрэглээг нэмэгдүүлж ажиллана.

2.4.5. "Угийн бичиг хөтөлцгөө" аян, арга хэмжээ зохион байгуулж, жил бүр 30-аас доошгүй өрхийг хамруулж үр дүнг тооцож ажиллана.

2.4.6. Соёлын ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулж, туршлага судлуулах, мэргэжлийн боловсон хүчнээр хангах ажлыг зохион байгуулна.

2.4.7. Орон нутаг сурталчлах танхимын тохижилтыг сайжруулах, үзмэрийн тоог нэмэгдүүлэх, соёлын биет болон биет бус өвийн бүртгэл мэдээллийн санг баяжуулж цахим, техник хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангана.

2.4.8. Соёлын төвийн гадаад дотоод орчин нөхцөлийг сайжруулж, хөгжим техник хэрэгсэлээр хангах ажлыг зохион байгуулна.

2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн бодлого:

Гэр бүл, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжиж, иргэн бүрт хүрсэн шүүрхай үйлчилгээг бий болгоно.

2.5.1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, "Хүчирхийлэлгүй сум" аяныг зохион байгуулна.

2.5.2. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэр бүл төлөвлөлтийн талаарх мэдлэг, мэдээллийг олгох ажлыг зохион байгуулна.

2.5.3. Хүүхэд залуучуудыг болзошгүй эрсдэл, осол гэмтэл, гэмт хэрэг, цахим орчны нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.5.4. Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, гэр бүлд зориулсан нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

2.5.5. Залуучуудын хөгжих, тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн клуб, холбоодын үйл ажиллагааг дэмжиж, залуучуудад нөлөөллийн ажлыг хэрэгжүүлнэ.

2.5.6. Аж ахуйн нэгж, байгууллагуудын нийгмийн хариуцлагын хүрээнд залуучуудын амьдрах орчин, боловсрол, гэр бүлд оруулах дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

2.5.7. Жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх ажлыг бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.

2.6. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, даатгал:

Иргэний аж ахуй эрхлэх үр чадварыг нь хөгжүүлж, дэмжлэг үзүүлэн ажилтай, орлоготой болгоно.

2.6.1. Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжтэй бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.6.2. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ өргөжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, санхүүжилт олгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.6.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчныг сайжруулах ажлыг төрийн болон аж ахуйн нэгж байгууллагуудад нэвтрүүлнэ.

2.6.4. Ахмад настны хөгжил, хамгааллын үйл ажиллагааг тогтмолжуулан, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.6.5. Сумын Ахмадын өргөөг ашиглалтанд оруулна.

2.6.6. Нийгмийн халамж, даатгал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамрагдах иргэдэд банк, төлбөр тооцооны цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.6.7. Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, сайн дурын даатгалд хамрагдагсдын тоог нэмэгдүүлнэ.

2.6.8.Иргэн бүрийг эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөөр урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах ажлыг зохион байгуулна.
2.6.9.Тусгай хэрэгцээт иргэдийг хөгжүүлж тэдний оролцоог ханган, ээлтэй орчин хөдөлмөрлөх нөхцөл боломжийг сайжруулна.

ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

3.1.Хөдөө аж ахуйн бодлого

Байгальд ээлтэй, үүр амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон цогц, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, эрчимжсэн хөдөө аж ахуйг хөгжүүлж эрүүл, аюулгүй хүнсний хангамжийг сайжруулна.

- 3.1.1.Атрын 4-р аяны хүрээнд газар тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
3.1.2.Газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлж, тариалангийн талбайн хөрсний үржил шимийг хамгаалан ойн зурвас, хашаажуулах төслийг хэрэгжүүлж, эрдэм шинжилгээний байгууллагууд, төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор ирээдүйтэй болон нутагшсан үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
3.1.3.Усалгаатай тариаланг хөгжүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран услах боломжтой талбайн судалгааг хийж, усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
3.1.4.Төмс хүнсний ногооны чанарын шаардлага хангасан үрээр хангах ажлыг зохион байгуулж, төмс хүнсний ногооны талбайг хашаажуулах ажлыг нэмэгдүүлж ажиллана.
3.1.5.Хүлэмжийн болон зоорины аж ахуй эрхлэлтийг дэмжиж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ.
3.1.6."Жимс жимсгэнэ" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, тариалах талбайн хэмжээ, нэр төрлийг олшруулж, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
3.1.7.Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн суурин, хагас суурин мал аж ахуйг эрхлэх иргэн аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжин ажиллана.
3.1.8.Сэлгээн дэх таримлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх замаар тариаланд ашиглагдах боломжтой атаршсан болон дахин хуваарилалтанд орж байгаа тариалангийн газруудыг эргэлтэнд оруулан тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлнэ.
3.1.9.Суманд Органик тариаланг хөгжүүлж, иргэдийн оролцоотой бүлэг хоршооны үйл ажиллагааг дэмжинэ.
3.1.10. Махны чиглэлийн Герефорд үүлдрийн үхрийн эрчимжсэн аж ахуй эрхлэхийг дэмжиж үе шаттайгаар хээлтүүлэгчээр хангах ажлыг зохион байгуулна.
3.1.11.Мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн чадавхийг сайжруулна.
3.1.12.Мал үржлийн үйлчилгээний нэгж байгуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
3.1.13.Бэлчээрийг нөхөн сэргээх хамгаалах үйл ажиллагааг сайжруулж, малчдын бүлэг хоршоо, бэлчээр ашиглагчдын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, оновчтой зохион байгуулалтанд оруулна.
3.1.14.Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулан борлуулах талаар гарсан санал санаачилгыг дэмжиж ажиллана.
3.1.15.Малчин дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж хэрэгжүүлнэ.
3.1.16.Зөгийн аж ахуй болон туслах аж ахуй эрхлэхийг дэмжин ажиллана.

3.2. Байгаль орчин:

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн бүй орчны бохирдол, доройтлыг бүүрүүлж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

- 3.2.1.Орон нутгийн төсөв болон ой ашиглагч иргэд, ойг хамгаалах нөхөрлөлдүүдийн оролцоотой жил бүр 5-10 га газарт ойн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэнэ.
3.2.2.Ойн хөнөөлт хортон шавжийн тархалтын судалгааг мэргэжлийн байгууллагаар жил бүр хийлгэж тархалтын судалгаанд тулгуурлан устгах ажлыг зохион байгуулна.
3.2.3.Ойн нөөцийг тогтоох, ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, бодит хэрэглээг үндэслэж эрх олгох ажлыг зохион байгуулна.Олгосон эрхийг нийтэд цахим хэлбэрээр мэдээллийн сан үүсгэж мэдээлнэ.
3.2.4.Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлж, түймэртэй тэмцэх чадавхийг нэмэгдүүлнэ.

3.2.5.Ойг хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж, Баян баавгайт нөхөрлөлийн мод боловсруулах ажиллагааны нийтэд үйлчлэх хэлбэрийг сайжруулна.

3.2.6. Хог хаягдлын төвлөрсөн цэгийг тохижуулж, айл өрх аж ахуйн нэгж байгууллагын хогийг нэгдсэн журмаар цуглуулж тээвэрлэх ажлыг тасралтгүй явагдахаар зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулж, мал бүхий иргэдийн үүсгэсэн малын гаралтай дахивар хогийг тусгайлсан цэгт хаях ажлыг хэвшүүлнэ.

3.2.7.Хог хаягдлын асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж ажиллана.

3.2.8.Сумын төвийн ус түгээх 3 цэгийн үйл ажиллагааг сайжруулан тогтмолжуулж, ухаалаг технологийг нэвтрүүлнэ.

3.2.9.Цэвэр усны ил ба далд шугам ашиглагч нарын ашиглалтыг нэмэгдүүлж, техникийн нөхцөл өгөх, төлбөрийн менежментийг шинэ аргаар гүйцэтгэнэ.

3.2.10.Ан амьтан байгалийн нөөц баялгийн зүй зохистой ашиглалтыг зохион байгуулж, хяналт шалгалтын ажлыг тогтмолжуулна.

3.3. Аялал жуулчлал:

Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлж, дотоод гадаадын жуулчдын ая тухтай амрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.1.Байгаль экологийн онцлог, түүх соёлын биет ба биет бус өв соёлыг хадгалсан НИТАЖ /нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал/-ыг хөгжүүлж Баянгийн арын даланг сэргээх ажлыг зохион байгуулна.

3.3.2.Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжинэ.

3.4. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ:

Худалдаа үйлчилгээний газруудыг орчин үеийн эрүүл ахуй, стандартын шаардлага хангуулж, үйлчилгээний чанар, харилцааны соёлыг дээшлүүлэх, ахуйн үйлчилгээг хөгжүүлж, нэр төрөл, чанар хүртээмжийг дээшлүүлж, хүний нөөцийг чадавхжуулна.

3.4.1.Суманд үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагаа, орчин нөхцөл, үйлчилгээний соёлыг сайжруулж, шинээр бий болж байгаа үйлдвэрлэл үйлчилгээг төр хувийн хэвшлийн хамтарсан хөрөнгө оруулалтаар дэмжиж ажиллана.

3.4.2."Сэлэнгийн брэнд" аймгийн хөтөлбөрийн хүрээнд, Сант брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн, дотоод гадаадын зах зээлд нийлүүлэх борлуулалтыг дэмжинэ.

3.4.3.Баялаг бүтээгч иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжиж ажиллана.

3.4.4. Худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны үйлдвэр, үйлчилгээний ажиллагсдыг сургах, мэргэшүүлэх, чадавхжуулах арга хэмжээ авч, сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн хоол зүйчтэй болгоно.

3.4.5."Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.4.6.Барилгын материалын үйлдвэрлэл болон үйлчилгээний санал, санаачилгыг дэмжин ажиллана.

3.5.Хөрөнгө оруулалт, дэд бүтэц:

Хүн амын орон сууц, эрчим хүч, ус хангамж, ариутгах татуургын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, иргэдийн эрүүл орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулна.

3.5.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.

3.5.2.Цахилгаан дамжуулах агаарын зарим шугамыг шинэчилж, хүчдэлийн уналттай айл өрх болон шинэ суурьшлын бүсийн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэнэ.

3.5.3. Иргэд болон төрийн албан хаагчдыг орон сууцжуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

3.5.4.Ардын хувьсгалын 100 жилийн ойн хүрээнд түүхэн болон дурсгалт газруудыг сэргээн засварлаж, тохижуулна.

3.5.5.Сэлэнгэ аймаг байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг тохиолдуулан бүтээн байгуулалт, тохижилт үйлчилгээний ажлуудыг хэрэгжүүлнэ.

3.5.6.Ивэн багийн нутагт байрлах Дарцаг, Түргэн, Шандын давааг засварлаж авто хөсөг зорчих таатай нөхцөл бүрдүүлнэ.

3.5.7.Сумын цэвэр усны магистраль шугамыг шинэчлэх ажлыг гүйцээж, зарим инженерийн шугам сүлжээг шинэчилж, цэвэрлэх байгууламжийн асуудлыг дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.5.8.Ахмадууд болон хүүхэд, залуучуудын чөлөөт цаг өнгөрөөх талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулна.

3.5.9.Ивэн голын даланг сэргээн засварлах ажлын холбогдох тооцоо судалгааг гаргаж дээд шатны байгууллагуудад хандан шийдвэрлүүлнэ.

3.5.10.Авто замын засвар арчлалтыг тогтмол хийж, шаардлагатай газруудад гэрэлтүүлэг нэмж, хуучин гэрэлтүүлгийг сэргээн засварлана.

3.6. Санхүү, төсвийн зохицуулалт:

Төсвийн ил тод байдал, сахилга батыг хангаж, төсвийн төлөвлөлтийн оновчтой хуваарилалт, зарцуулалтыг удирдан,иргэд олон нийтийн санхүү, төсвийн мэдлэгийг дээшлүүлнэ.

3.6.1.Эдийн засгийн нөөц бололцоонд тулгуурласан төсвийн төлөвлөлтийг оновчтой зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтын системийг сайжруулж, үр дүнгийн шинжилгээнд суурилан төсвийн ил тод байдлыг хангана.

3.6.2.Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, тайлагналт, үйл ажиллагааг цахимжуулж, хуулийн хүрээнд татвар ногдуулах боломжийг эрэлхийлж татварын суурийг нэмэгдүүлнэ.

3.6.3.Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.

3.6.4.Статистикийн мэдээ, тооллого, судалгааг үнэн, бодитой хийж, үр дүнгийн шинжилгээнд суурилсан мэдээллийг хэрэглэгчдэд боломжит хэлбэрээр тархааж, бодлогын баримт бичиг боловсруулах үйл ажиллагаанд ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.6.5.“Иргэн та эдийн засагч” арга хэмжээг хэрэгжүүлж, төсөв санхүүгийн ил тод байдлыг цахим хэлбэрээр иргэдэд мэдээлнэ.

3.6.6.Улс , аймаг сумын Орон нутгийн хөгжлийн сан, бусад хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээнд явцын хяналтыг сайжруулж , бүртгэлд тусгах арга хэмжээг хэрэгжүүлэх

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

4.1.Нутгийн захиргаа:

Төрийн үйлчилгээнд ухаалаг-тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ.

4.1.1.Мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, чадахуйн зарчимд тулгуурласан ухаалаг, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ.

4.1.2.Төрийн албан хаагчийн ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж, төрийн бүх шатны байгууллагад суралцагч байгууллагын соёлыг бэхжүүлнэ.

4.1.3.Төрийн албан хэрэг хөтлөлтийг кирил болон үндэсний бичгээр хослуулан явуулах бэлтгэл ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.

4.1.4.Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг хэрэгжүүлж, цахим үйлчилгээний хэрэглээг нэмэгдүүлнэ.

4.1.5.Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан “**Таныг сонсьё**” арга хэмжээг төрийн бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлж, захиргааны шийдвэр гаргах, хянах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.1.6.Олон улсын болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг өргөжүүлж, уламжлалт харилцааг бэхжүүлэн шинэ түншлэлийг нэмэгдүүлж, гадаад хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ.

4.1.7.Сумын төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаа болон хөгжлийн бодлогын баримт бичигт төлөвлөлт, явц, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, үр дүнг тооцох тогтолцоог бэхжүүлнэ.

4.1.8. Багийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, багаас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулна

4.1.9.Төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэр, ажил үйлчилгээг мэдээллийн олон хэлбэрээр иргэдэд сурталчилж,улиралд нэг удаа Сантын өнөөдөр сонин гаргаж нийтийн хүртээл болгоно.

4.1.10.Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагаанд бүх нийтийн оролцоог хангаж, гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлнэ.

4.2. Хууль эрх зүй:

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх замаар иргэн бүр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг төлөвшлийг бий болгож, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хангах ажлыг дээшлүүлж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

- 4.2.1. "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгжилтийг суманд хангах бодлого"-ыг хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай хүргэн иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.
- 4.2.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана.
- 4.2.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг нийтэд түгээн авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх хандлагыг төлөвшүүлнэ.
- 4.2.5. Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгож, иргэн бүрийн аюулгүй байдлаа хангах мэдлэг, мэдээллийг нийгэмд түгээн, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 4.2.6. Стандарт, шаардлагад нийцсэн архивын өрөө тасалгааг тохижуулж, архивын үйл ажиллагааг сайжруулна.
- 4.2.7. "Нэг иргэн-нэг бүртгэл" арга хэмжээг үргэлжлүүлэн улсын бүртгэлийн мэдээллийг цахимаар авах боломж нөхцөлийг суманд бүрдүүлнэ.
- 4.2.8. Малын хулгайтай тэмцэх ажлын үр дүнг тооцож дэмжин ажиллана.

4.3. Батлан хамгаалах:

Орон нутгийн хамгаалалтын тогтолцоо бэхжиж, батлан хамгаалах чадавх дээшилсэн байна.

- 4.3.1. Цэргийн насны залуучуудыг алба хаах хүсэл сонирхолыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.3.2. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, "Дөл" тэмцээнийг зохион байгуулна.
- 4.3.3. Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын түвшинг дээшлүүлж, цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа иргэдийг сумын бүтээн байгуулалт болон хүмүүнлэгийн ажиллагаанд татан оролцуулна.

ТАВ.НОГООН ХӨГЖИЛ

Байгалийн үнаган төрхийг хадгалж, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглан, байгальд ээлтэй үзэл санааг түгээн дэлгэрүүлнэ.

- 5.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад тогтвортой ногоон хот, ногоон барилга, амьдралын ногоон хэв маяг, нөөцийн хэмнэлт зэрэг байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг дэмжих, мэдлэг олгоно.
- 5.1.2. "Ногоон сум" хөдөлгөөнийг өрнүүлж, төрөл бүрийн суулгац үржүүлэх иргэдийн санал санаачилгыг дэмжин ажиллана.
- 5.1.3. Гэр хорооллын болон аялал жуулчлалын бүсэд "Био жорлон" арга хэмжээг зохион байгуулж, хөрсний бохирдлыг бууруулна.
- 5.1.4. Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, зэрлэг ургамал устгах ажлыг жил бүр зохион байгуулж гудамж талбайг цэгцлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 5.1.5. Агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд мэдээлж, зөв дадалд сургана.

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**